



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/131/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас:88106992 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ЗОРИГТ ТАНАА

2020.02.27 № 247
танай _____ -ны № _____ -г
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Өлзийт сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлзийт сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020204

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга М.Зоригт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.04-өөс 2020.02.05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.25-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2019.12.10-ны өдрийн 155 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газарт /цаашид Тамгын газар гэх/ Монгол Улсын хууль тогтоомж, Төр засгийн шийдвэрийг мөрдүүлж хэрэгжүүлэх, нийт ажилтнуудын ажил үүргийг оновчтой зохион байгуулж, эвсэг бүтээлч хамт олныг төлөвшүүлэн, хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэн, хариуцлагыг өндөржүүлж, байгууллагын дотоод ажлыг эмх цэгцтэй, шуурхай байлгах, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглан, ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, албан хаагчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон болох
- Төрийн чиг үүргийг иргэдэд хүртээмжтэй, түргэн шуурхай, сэтгэл ханамжтай хүргэхэд оршино гэж үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 36 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 35 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 355548,6 мянган төгрөгөөс тооцон 7110,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгийн 2% буюу 10082,9 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 127,277.0 мянган төгрөгөөр буюу 12,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	1,100.0	1,063.2	36.8
Бараа материал	70,061.4	88,545.8	18,484.4
Үндсэн хөрөнгө	2,363,596.4	2,407,112.4	43,516.0
Хуримтлагдсан элэгдэл	-583,037.3	-517,724.1	-65,313.2
Нийт хөрөнгө	1,851,720.5	1,978,997.5	127,277.0
Өр төлбөр	6,538.6	0	-6,538.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,845,181.9	1,978,997.5	133,815.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,851,720.5	1,978,997.5	127,277.0

Авлагын үлдэгдэл 1063,2 мянган төгрөг байгаа нь 2017 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор Кама маркын хогын автомашиныг актлан Баянлиг сумын ЗДТГ-ын даргатай гэрээ байгуулан тус сумд 4000,0 мянган төгрөгөөр худалдан борлуулсны төлбөрийг 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр 3000,0 мянган төгрөгийг барагдуулж үлдэгдэл 1000,0 мянган төгрөгийг 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагаар тусгуулсан байна. Мөн 63,2 мянган төгрөгийн авлага нь жирэм амаржсаны амралтай байсан албан хаагчийн цалинг мэдээлэхдээ кодыг буруу андуурч мэдээлснээс болж үүсчээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,484.4 мянган төгрөгөөр өссөн нь ХХААГ-аас 5100.0 мянган төгрөгийн мал, ОНХС-аас 8000.0 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, 11816,0 мянган төгрөгийн өвс өвс тэжээлийг үнэ төлбөргүй авч орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 53516,0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 36500,0 мянган төгрөгийн ланд-100 маркын автомашин, 15273,0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 1850,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 9019,5 мянга төгрөг, Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацаас 133291,8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Их зам ХХК-аас 1750,0 мянган төгрөгийн Мотоцикл, Шаргал угалз ХХК-аас 4000,0 мянган төгрөгийн жайлуузан болон хагас автомат хуйлдаг хөшиг, 1-р багийн малчдын хандиваар 13855,6 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй орлогоор бүртгэн авч 167074,0 мянган төгрөгийн хөрөнгө актлан, 24500,0 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланс-д шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1978997,4 мянган төгрөг болж 133815,5 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардал байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй дахин үнэлгээний дансанд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 600,0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 1100,0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 183,3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Түрээсийн орлого	600,0	1100,0	0,5	183,3
Нийт дүн	600,0	1100,0	0,5	183,3

Өөрийн орлого 400,0 мянган төгрөгөөр өссөн нь бага оврын тракторыг түрээсийн гэрээгээр эзэмшүүлснээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 зориулалтад 362720,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 362720,8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 362120,8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 600,0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 361913,1 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь зарцуулаагүй үлдэгдэл 807,6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Нэмэлт төсөв: Өмнөх оны үлдэгдэл санхүүжилтээр 14827,8 мянган төгрөг, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын зардал 500 мянга, тус суманд үйл ажиллагаа явуулж буй ААНБ-аас Байгаль орчны нөхөн сэргээлтийн мөнгө 5000,0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 5300,0 мянган төгрөг, тендерийн орлого 257,4 мянган төгрөг, өвс тэжээлийн үнэ 7370,0 мянган төгрөг, түрээсийн орлого 300,0 мянган төгрөг буюу 33555,2 мянган төгрөгийг бүрдүүлжээ. Үүнээс Хамтарсан багийн үйл ажиллагаанд 500,0 мянга, Өвс тэжээл худалдан авахад 18190,0 мянга, ЗДТГ-ын газрын үйл ажиллагааны зардалд 13352,1 мянган төгрөгийг зарцуулж 1513,1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 36 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 11 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 25 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар нийт 5345,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 500,0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 4845,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 5345,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 500,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл

Тайлант хугацаанд 2019.12.25-ны өдрийн 18 тоот төлбөрийн хүсэлтээр ЗЭББ ХХК-руу зочид төлөөлөгчид хүлээн авах зардлаас ундаа ус хоолны зардалд 500.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаад зочид төлөөлөгчийн зардалд "МУ-ыг болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбоотой гарах зочид буудал, хоол,унаа, бэлэг дурсгалын эд зүйлс олгоход зарцуулна" гэсэн төсвийн зарлагын ангиллыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 4845,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, шатахууны зарцуулалт, кассаар болон нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулж буй орлого, зарлага, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулах цаг хугацааны боломжгүйгээс үзээгүй болно.

2.13 Шилэн дансны мэдээлэл:

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	35	1	
5	Тухай бүр	8	96	93	3	
	Нийт	27	151	143	4	2

Төсвийн гүйцэтгэл/бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/ мэдээг 5-р сард, Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр), Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлбар /бүтэн жил, хагас жилээр/ мэдээг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар /тухай бүр/ мэдээг 4-р сард, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө мэдээг бүтэн жилээр мэдээг хугацаанд нь байршуулаагүй байна.

2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон актын төлбөрийг 100 хувь биелүүлсэн байна.

2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данс

3.1.1 Илрүүлэлт:

Зочид төлөөлөгчид хүлээн авах зардалд батлагдсан 4500.0 мянган төгрөгөөс 1620.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, 2880.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Гадаад зочид төлөөлөгчийн зардалд “МУ-ыг болон бусад орны албан төлөөлөгч айлчлахтай холбоотой гарах зочид буудал, хоол,унаа, бэлэг дурсгалын эд зүйлс олгоход зарцуулна” гэсэн төсвийн зарлагын ангиллыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Зардалд бүртгэлээр тавих хяналт сулрах, үргүй зардал гарах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хууль, Сангийн сайдын холбогдох журмуудыг мөрдөж ажиллан цаашид зочид төлөөлөгчийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 Урсгал засварын зардал

3.2.1 Урсгал засварын зардлаас гэрэлтүүлгийн үнэ 1600.0 мянган төгрөгийг Би Ай Эм Би ХХК-д, бүрээсний үнэ 365.0 мянган төгрөг Олон хос хоршоонд тус тус төлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2. батлагдсан төсөв,

хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Урсгал засварын зардал /байгууллага өөрийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламжид урсгал засвар хийхтэй холбоотой гарсан зардал засвар үйлчилгээний материал авах, засвар үйлчилгээний хөлс / гэх мэт" гэсэн төсвийн зарлагын ангиллыг тус тус зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл

Үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх, төсвийн зарцуулалтад тавих хяналт сул байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж Холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллаж төсвийг зарцуулахдаа төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, цаашид гаргасан алдаа зөрчлийг давтан гаргахгүй.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно..

3.3 Үндсэн хөрөнгө

3.3.1 Илрүүлэлт: ОНХС-ын хөрөнгөөр 2017 онд худалдан авсан 10000,0 мянган төгрөгийн үнэтэй хогийн автомашин нь ЗДТГ-ын хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч 49-68 УНТ улсын дугаартай тээврийн хэрэгслийн эзэмшигчийн гэрчилгээ нь Дуламсүрэнгийн Төмөр гэсэн иргэний нэр дээр бүртгэлтэй байна.

Энэ нь Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна", Авто тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т "Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараах үүрэг хүлээнэ", 19.3.1 техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах; 19.3.2-т "авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн бичиг баримтын бүрдлийг хангах" гэсэн заалтыг тус тус зөрчиж "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа цаг хугацаандаа хийгдэхгүй, холбогдох дүрэм журмыг мөрдөхгүй байгааг нь хөрөнгө дутагдах шамшигдах

3.3.3 Өгсөн зөвлөмж

Автомашин эзэмшигчийн гэрчилгээг байгууллагын нэр дээр бүртгэлийг шилжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

3.4.1 Илрүүлэлт

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй НБББББ-т байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт,

дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2. “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт заавар журамд нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж хамт олны хурлаар хэлэлцүүлж, баталгаажуулж мөрдөж ажиллан, санхүү бүртгэлтэй холбоотой алдаа зөрчлийг бууруулах арга хэмжээ авах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

